

Аймгийн Засаг дарга Х.Дармен БНХАУ-ын ШУОЗО-ны Гадаад арилжаа, худалдааны тэнхимийн дарга Ху Жампин, Алтай аймгийн гадаад худалдааны товчооны орлогч Женис тэргүүтэй толоологчдийг хвлээн авч уулзлаа. Уулзалтаар хоёр талд Даян-Улаан уулын хилийн боомтын цаашдын вйл ажиллагаа, хамтын ажиллагаа, дэд бүтцийн асуудлаар санал солилцов. Монгол, Хятадын Засгийн газрын хамтарсан шийдвэрээр Даян - Улаан уулын хилийн боомтыг 6 дугаар сарын 01-нээс 10 дугаар сарын 01-ний хүртэл 120 хоног тогтмол ажиллуулахаар тохиролцож, одоогийн байдлаар ажлын өдрүүдээр 08:30-12:30, 14:30-18:30 цагуудын хооронд тогтмол ажиллаж байгаа билээ.